

**МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН
ХООРОНД ИРГЭН, ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, ЭРҮҮГИЙН
ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ
БОЛОН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ГЭРЭЭ**

Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улс эрх зүйн туслалцаа болон эрх зүйн харилцааны хүрээнд харилцан хамтын ажиллагааг хөгжүүлэхэд өндөр ач холбогдол өгч дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ
Нийтлэг үндэслэл**

**1 дүгээр зүйл
Эрх зүйн хамгаалалт**

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр хувийн болон эд хөрөнгийн хэргийн талаар Хэлэлцэн тохирогч энэ Талын иргэний нэгэн адил эрх зүйн хамгаалалт эдэлнэ.
2. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний нэгэн адил нөхцөлөөр иргэн, гэр бүл, хөдөлмөрийн болон эрүүгийн хэрэг хэлэлцэх шүүх, прокурор /цаашид "хууль сахиулах байгууллага" гэх/ болон бусад байгууллагад чөлөөтэй, саадгүй хандах эрхтэй бөгөөд тэдгээрийн ажиллагаанд оролцох, нэхэмжлэл болон хүсэлт гаргах түүнчлэн бусад байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхтэй.
3. Хэлэлцэн тохирогч хоёр Талын иргэдэд хамаарах энэхүү Гэрээний заалт нутаг дэвсгэрт нь оршин байгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

**2 дугаар зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэх**

1. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль сахиулах байгууллага иргэн, гэр бүл, хөдөлмөрийн болон эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн туслалцааг энэхүү Гэрээний дагуу бие биендээ үзүүлнэ.
2. Хууль сахиулах байгууллага нь энэ зүйлийн 1-д дурдсан хэргийн талаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын бусад байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлнэ.
3. Эрх бүхий бусад байгууллага нь энэ зүйлийн 1-д дурдсан хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварыг хууль сахиулах байгууллагаар уламжлан явуулна.

**3 дугаар зүйл
Эрх зүйн туслалцааны хүрээ**

Эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид заасан байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлнэ. Тухайлбал зохигчид, хохирогч, сэжигтэн, яллагдагч, гэрч болон шинжээчийг байцаах, үзлэг явуулах, эд мөрийн баримт шилжүүлэх, баримт бичиг гардуулах болон илгээх, түүнчлэн ял эдэлж байсан тухай мэдээлэл хүргүүлэх зэрэг үйлдэл хамаарна.

**4 дүгээр зүйл
Харилцах журам**

1. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль сахиулах байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлэх хэргийн талаар харилцахдаа:
 2. Монгол Улсын хувьд: Монгол Улсын Хууль зүйн яам,
Бүгд Найрамдах Польш Улсын хувьд: Бүгд Найрамдах Польш Улсын Хууль зүйн яамаар
уламжлан харилцана.
3. Энэ зүйлийн 1-д дурдсан Хэлэлцэн тохирогч хоёр Талын төв байгууллага, хууль сахиулах байгууллагууд хоорондоо шууд харилцах талаар нэмэлт хэлэлцээр байгуулж болно.

**5 дугаар зүйл
Хэрэглэх хэл**

1. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаврыг уг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын албан ёсны хэл дээр үйлдэж, даалгавар хүлээн авах Хэлэлцэн тохирогч Талын албан ёсны хэл рүү, эсхүл англи буюу орос хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг хавсаргана.
2. Эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ баримт бичгийг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын албан ёсны хэл дээр үйлдэж, даалгавар хүлээн авах Хэлэлцэн тохирогч Талын албан ёсны хэл рүү, эсхүл англи буюу орос хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг хавсаргана.
3. Хэрэв энэхүү Гэрээний заалтын дагуу явуулах баримт бичигт орчуулга хавсаргах шаардлагатай бол орчуулгыг итгэмжлэгдсэн орчуулагч, нотариатч, эрх бүхий байгууллага буюу дипломат төлөөлөгчийн болон консулын газраар гэрчлүүлсэн байна.

6 дугаар зүйл
Баримт бичгийн бүрдэлт

Энэхүү Гэрээг үндэслэн бүрдүүлсэн Хэлэлцэн тохирогч аль нэг Талын баримт бичигт эрх бүхий байгууллагын албан ёсны тамга, тэмдэг дарж, эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна.

7 дугаар зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаврын хэлбэр

1. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт дараахь зүйлийг тусгасан байна:
 - 1/ даалгавар өгсөн байгууллагын нэр;
 - 2/ даалгавар хүлээн авах байгууллагын нэр;
 - 3/ эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт заасан хэргийн нэр;
 - 4/ хэргийн талаар даалгавар бүрдүүлсэн зохигчид болон бусад этгээдийн овог, нэр, иргэний харьяалал, мэргэжил, оршин суугаа буюу оршин байгаа газар, хуулийн этгээдийн хувьд түүний нэр болон оршин байгаа газар;
 - 5/ дээрх этгээдийг төлөөлөх хүмүүсийн овог, нэр болон хаяг;
 - 6/ даалгаврын агуулга, эрүүгийн хэргийн хувьд гэмт хэргийн талаарх нэмэлт тодорхойлолт, түүний хуулийн зүйлчлэл.
2. Эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ Хэлэлцэн тохирогч хоёр Талын төв байгууллага харилцан тохиролцсоны үндсэн дээр монгол, польш хэлээр үйлдсэн хэвлэмэл хуудас хэрэглэж болно.

8 дугаар зүйл
Даалгавар биелүүлэх журам

1. Даалгавар хүлээн авсан байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ. Хэрэв даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид харшлахгүй бол даалгавар хүлээн авсан байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр хэрэглэж болно.
2. Даалгавар хүлээн авсан байгууллага уг даалгаврыг биелүүлэх эрх бүхий бус байвал түүнийг эрх бүхий байгууллагад шилжүүлэн өгч, энэ тухай даалгавар өгсөн байгууллагад мэдэгдэнэ.
3. Даалгавар хүлээн авсан байгууллага нь түүнийг биелүүлсэн газар, хугацааг даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр өөрт нь мэдэгдэнэ.
4. Даалгавар хүлээн авсан байгууллага даалгавар биелүүлсний дараа даалгавар өгсөн байгууллагад баримт бичгийг буцаах бөгөөд даалгавар биелүүлэх боломжгүй тохиолдолд даалгаврыг буцааж, биелүүлээгүй шалтгааныг мэдэгдэнэ.
5. Хэрэв даалгаварт заасан этгээдийн хаяг буруу, эсхүл тодорхой бус бол даалгавар хүлээн авсан байгууллага зөв хаягийг олж тогтоох талаар зохих арга хэмжээ авна.

9 дүгээр зүйл
Баримт бичиг гардуулах

Хэрэв гардуулан өгөх баримт бичиг даалгавар хүлээн авсан Талын албан ёсны хэл дээр үйлдэгдсэн, эсхүл нөгөө Талын хэлнээс хөрвүүлсэн баталгаат орчуулгыг хавсаргасан байвал даалгавар хүлээн авсан байгууллага өөрийн улсад мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу гардуулна.

Баримт бичиг нь даалгавар хүлээн авсан Талын хэл дээр үйлдэгдээгүй, эсхүл орчуулгыг хавсаргаагүй бол хүлээн авагч этгээд сайн дураар хүлээн авахыг зөвшөөрвөл уг баримт бичгийг гардуулна.

10 дугаар зүйл
Гардуулсны баталгаа

Баримт бичгийг гардуулсны баталгаа нь гардуулсан огноо, хүлээн авсан болон баримт бичиг гардуулсан этгээдийн гарын үсэг, даалгавар хүлээн авсан байгууллагын албан ёсны тамга, тэмдэг бүхий гардуулсан тухай нотолгоо, эсхүл гардуулсан огноо, газар, арга замыг заасан гардуулан өгөх

байгууллагын гэрчлэх баримт байна. Хэрэв хоёр хувь баримт бичиг гардуулсан бол гардуулж өгсөн баталгааг нэг хувь дээр үйлдэж болно.

11 дүгээр зүйл

Дипломат төлөөлөгчийн буюу консулын газраар дамжуулан иргэдэд баримт бичиг гардуулах, асуулт тавих

Хэлэлцэн тохирогч хоёр Тал дипломат төлөөлөгчийн буюу консулын газраараа дамжуулан өөрийн иргэдэд баримт бичиг гардуулах, асуулт тавих эрхтэй. Энэ тохиолдолд албадлагын шинж чанартай арга хэмжээ хэрэглэж болохгүй.

12 дугаар зүйл

Гэрч, хохирогч, шинжээчийг дуудах, тэдгээрийн баталгаа

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын хууль сахиулах байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа гэрч буюу шинжээчийг биечлэн дуудах шаардлагатай гэж үзвэл зарлан дуудах хуудас гардуулах даалгаврыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий хууль сахиулах байгууллагад өгнө.
2. Дуудлагын дагуу ирээгүй тохиолдолд албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай ямар нэгэн заналхийлэл зарлан дуудах хуудаст тусгасан байж болохгүй.
3. Хэлэлцэн тохирогч тухайн Талын эрх бүхий байгууллагын дуудлагаар хүрэлцэн ирсэн гэрч буюу шинжээчийг аль улсын харьяат болохыг үл харгалзан тэр нутаг дэвсгэрт гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдуулан хариуцлагад татах, түүнийг дуудан шалгаж байгаа тухайн хэрэгт, түүнчлэн түүнийг улсын хил нэвтрэхийн өмнө үйлдсэн ямар нэг үйлдэлд, тэдний гаргасан гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлттэй холбогдуулан цагдан хорих буюу ял эдлүүлж болохгүй.
4. Гэрч буюу шинжээч нь даалгавар өгсөн байгууллагаас цаашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэнээс хойш даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс таван хоногийн дотор гарч яваагүй бол дээрх баталгаагаа алдана. Энэ хугацаанд гэрч буюу шинжээч нь даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс өөрөөс нь үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас гарч яваагүй хугацааг оруулж тооцохгүй.
5. Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт дуудагдаж ирсэн гэрч буюу шинжээч нь хил нэвтрэх болон хилийн чанадад байх зардал, мөн ажиллаагүй хугацааны цалингаа нөхөн төлүүлэх, түүнчлэн шинжээчээр ажилласны шагналыг авах эрхтэй. Дуудагдаж буй этгээд ямар зардал авах эрхтэйг зарлан дуудах хуудаст заасан байна. Дуудлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал уг этгээдийн хүсэлтээр зардлын урьдчилгаа олгоно.
6. Мэдүүлэг өгөхөөр дуудагдаж ирсэн хохирогчдод энэ зүйлийн 5-д заасан нөхцөлийг нэгэн адил хэрэглэнэ.

13 дугаар зүйл

Баримт бичгийг хүлээн зөвшөөрөх

1. Хэлэлцэн тохирогч тухайн Талын эрх бүхий байгууллагын үйлдсэн албан ёсны тамга, тэмдэг, эрх бүхий этгээдийн гарын үсэгтэй баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ямар нэгэн нотолгоогүйгээр хүлээн зөвшөөрнө. Энэ заалт нь эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан орчуулга, баримт бичгийн хуулбарт нэгэн адил хамаарна.
2. Хэлэлцэн тохирогч тухайн Талын нутаг дэвсгэр дээр албан ёсны гэж хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичиг нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэгэн адил хүлээн зөвшөөрөгдөнө.

14 дүгээр зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардал

1. Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр гарсан эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг хариуцна.
2. Даалгавар хүлээн авсан байгууллага гарсан зардлын тухай дүнг даалгавар гаргасан байгууллагад мэдэгдэнэ. Даалгавар өгсөн байгууллага уг зардлыг төлөх үүрэг бүхий этгээдээс нөхөн гаргуулж авсан бол тэр нь зардлыг гаргуулж авсан Хэлэлцэн тохирогч Талын орлого болно.

15 дугаар зүйл

Мэдээлэл өгөх

1. Хэлэлцэн тохирогч хоёр Талын төв байгууллага иргэн, гэр бүл, хөдөлмөрийн болон эрүүгийн эрх зүйн салбар дахь нэн чухал хууль тогтоомжийн баримт бичгийг хоорондоо солилцоно.

2. Хэлэлцэн тохирогч хоёр Талын төв байгууллага өөрийн оронд дагаж мөрдөж байгаа хуулийн заалт болон түүнийг хэрэглэж буй практик асуудлаарх мэдээллийг хүсэлтийн дагуу харилцан бие биедээ илгээж байна.

16 дугаар зүйл
Эд зүйл, мөнгө шилжүүлэх

Энэхүү Гэрээг биелүүлэхэд Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт, мөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт эд зүйл, мөнгө шилжүүлэх тохиолдолд шилжүүлж буй байгууллагын Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл
Хаяг, бусад зүйлийг тогтоох

1. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль сахиулах байгууллага өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа этгээдийн хаяг, бусад зүйлийг тогтоох талаар хүсэлтийн дагуу харилцан бие биендээ туслалцаа үзүүлнэ.
2. Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа этгээдээс хүүхдийн тэтгэлэг төлүүлэх тухай нэхэмжлэл гаргавал Хэлэлцэн тохирогч энэ Талын хууль сахиулах байгууллага хүсэлтийн дагуу хариуцагчийн ажлын газар, орлогын хэмжээг тогтооход туслалцаа үзүүлнэ.

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн
тухай болон бусад баримт бичиг илгээх

18 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч хоёр Талын эрх бүхий байгууллага иргэний гэр бүлийн байдлын бүртгэлээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнд хамаарах мэдээллийг харилцан бие биендээ илгээнэ. Эдгээр мэдээллийг иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд тэмдэглэмэгц үнэ төлбөргүй даруй илгээнэ.
2. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд тайлбар, засвар буюу нэмэлт оруулбал энэ зүйлийн 1-д заасан нөхцөлийг нэгэн адил хэрэглэнэ. Энэ тохиолдолд иргэний гэр бүлийн байдлын бүртгэлээс тухайн өөрчлөлтийг тусгасан хуулбарыг илгээнэ.
3. Хэлэлцэн тохирогч хоёр Талын иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хууль сахиулах байгууллагын хүсэлтийн дагуу иргэний гэр бүлийн байдлын талаарх холбогдох мэдээллийг илгээж байна.
4. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлээс мэдээлэл авахыг хүссэн Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэний хүсэлтийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх эрх бүхий байгууллагад шууд илгээж болно. Хүсэлт гаргагч нь эдгээр баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газраар дамжуулан авч холбогдох хураамжийг төлнө.

19 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнд хамаарах иргэний гэр бүлийн байдлын талаарх хүчин төгөлдөр болсон шийдвэрийн хуулбарыг Хэлэлцэн тохирогч хоёр Тал харилцан бие биендээ илгээнэ.

20 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэний хүсэлтийн дагуу тэдний боловсрол, ажилласан хугацааны тухай, хувийн болон эд хөрөнгийн эрх, ашиг сонирхолд хамаарах бусад баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад шууд илгээх буюу шилжүүлж болно. Эдгээр баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад шууд илгээх буюу шилжүүлж болно. Эдгээр баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газраар дамжуулан уг иргэнд гардуулна. Дипломат төлөөлөгчийн буюу консулын газар нь иргэнд баримт бичиг гардуулахдаа ийнхүү олгосны хураамж авна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ
Иргэн, гэр бүлийн болон хөдөлмөрийн хэрэг

Нэгдүгээр бүлэг
Байцаан шийтгэх ажиллагаатай холбогдох
зардал болон хөнгөлөлт

21 дүгээр зүйл
Байцаан шийтгэх ажиллагааны
зардлаас чөлөөлөх

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын шүүхийн ажиллагаанд оролцож байгаа тухайн улсын нутаг дэвсгэрт оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнд гадаадын харьяат буюу тухайн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт оршин суудаггүй буюу амьдардаггүй гэсэн үндэслэлээр байцаан шийтгэх ажиллагаа явуулах зардлыг төлөх үүрэг оногдуулж болохгүй.

Шүүхийн зардлаас чөлөөлөх
22 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр байцаан шийтгэх ажиллагаа явуулах төлбөр, урьдчилгаа болон бусад зардлаас чөлөөлөгдөх бөгөөд Хэлэлцэн тохирогч энэ Талын иргэний нэгэн адил нөхцөл, хэмжээнд үнэ төлбөргүй төлөөлүүлэх эрх эдэлнэ.
2. Энэ зүйлийн 1-д заасан хөнгөлөлт нь шийдвэрийг биелүүлэх ажиллагааг оролцуулан тухайн хэргийн талаар явуулж байгаа байцаан шийтгэх бүх ажиллагаанд нэгэн адил хамаарна.
3. Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхээс тодорхой хэргийг шүүхийн зардлаас чөлөөлөх нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэ хэргийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар үүссэн зардалд нэгэн адил хамаарна.

23 дугаар зүйл

1. Байцаан шийтгэх ажиллагааны зардлаас чөлөөлөгдөх буюу үнэ төлбөргүй төлөөлүүлэх зөвшөөрөл авахын тулд хүсэлт гаргагчийн хувийн болон гэр бүл, эд хөрөнгийн байдлын талаар тодорхойлолтыг гаргана. Энэ тодорхойлолтыг өргөдөл гаргагч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагаас олгоно.
2. Хүсэлт гаргагч нь Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэрт оршин суудаггүй буюу оршин байдаггүй бол хүсэлт гаргагч харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газраас тодорхойлолт олгоно.
3. Зардлаас чөлөөлөх тухай шийдвэр гаргаж байгаа шүүх тодорхойлолт олгосон байгууллагаас нэмэлт мэдээ буюу мэдээллийг бүрэн болгохыг шаардаж болно.

24 дүгээр зүйл

1. Шүүхийн зардлаас чөлөөлүүлэх буюу байцаан шийтгэх ажиллагаанд үнэ төлбөргүй төлөөлүүлэх тухай хүсэлтийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүхэд гаргах хүсэлтэй байгаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн уг хүсэлтийг амаар буюу бичгээр гаргаж өөрийн оршин суугаа буюу оршин байгаа газрын эрх бүхий шүүх хуралдааны тэмдэглэлд бичүүлнэ. Шүүх энэхүү Гэрээний 23 дугаар зүйлд заасан тодорхойлолтын хамт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий шүүхэд зохих журмын дагуу илгээнэ.
2. Энэ зүйлийн 1-д дурдсан хүсэлтийг нэхэмжлэл буюу бусад баримт бичгийн хамт гаргаж болно.

25 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүх Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа буюу оршин байгаа зохигчид буюу оролцогчдын шүүхийн зардлыг төлөх, эсхүл нэхэмжлэл, хүсэлтийн бүрдэлт дутууг гүйцээх үүрэг өгөх бөгөөд үүний тулд нэг сараас доошгүй хугацаа тогтооно. Хугацааг зохих мэдэгдэл гардуулсан өдрөөс эхлэн тооцно.

26 дугаар зүйл
Хугацаа

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүх Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа зохигчид буюу оролцогчдод байцаан шийтгэх ажиллагаа явуулах хугацаа тогтоосон бол нутаг дэвсгэрээс нь шаардлага бүхий баримт бичгийг явуулсан Хэлэлцэн тохирогч Талын шуудангийн байгууллагын дарсан тэмдгээр хугацааг тооцно.
2. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрээс тогтоосон хугацаанд шүүхээс шаардсан төлбөр болон урьдчилгааг шилжүүлэх тохиолдолд уг зохигчид болон оролцогчид нутаг дэвсгэрт нь оршин сууж байгаа Хэлэлцэн тохирогч Талын банкинд оруулсан огноогоор хугацааг тогтоон тооцно.
3. Хугацаа зөрчсөний улмаас гарах үр дагаварт хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх өөрийн улсын хууль тогтоомжийг баримтална.

Хоёрдугаар бүлэг
Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх
/тогтоол, таслан шийдвэрлэх тогтоол/

27 дугаар зүйл
Эд хөрөнгийн бус хэргийн талаарх шийдвэрийг
хүлээн зөвшөөрөх

Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхээс гаргасан эд хөрөнгийн бус эрх зүйн харилцаанд үүссэн иргэн, гэр бүл, хөдөлмөрийн хэргийн талаарх хуулийн хүчин төгөлдөр, харин эцэг, эхийн эрх хэмжээтэй холбогдсон хэргийн талаарх хуулийн хүчин төгөлдөр болоогүй шийдвэрийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүх энэ хэрэгт холбогдуулан өмнө нь хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гаргаагүй, түүнчлэн дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу онцгой эрх хэмжээгүй бол хүлээн зөвшөөрөх ажиллагаа явуулахгүйгээр энэ Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрнө.

28 дугаар зүйл
Биелүүлэх шаардлагатай эд хөрөнгийн болон
эд хөрөнгийн бус хэргийн талаарх шийдвэрийг
хүлээн зөвшөөрөх, биелүүлэх

1. Энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу Хэлэлцэн тохирогч хоёр Тал өөрийн нутаг дэвсгэр дээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гаргасан дараахь шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлнэ:
 - 1/ иргэн, гэр бүлийн болон хөдөлмөрийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр;
 - 2/ эрүүгийн хэргийн талаарх шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэсэг.
2. Энэ зүйлийн 1-д заасан шүүхийн шийдвэр гэдэгт эд хөрөнгийн шинжтэй иргэн, гэр бүлийн болон хөдөлмөрийн хэргийн талаарх шүүхээр шийдвэрлэсэн эвийн хэлэлцээ хамаарна.

29 дүгээр зүйл

Энэхүү Гэрээний 28 дугаар зүйлд дор дурдсан шийдвэр нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт дараахь тохиолдолд хүлээн зөвшөөрч биелүүлнэ. Хэрэв:

- 1/ Хэлэлцэн тохирогч тухайн Талын хууль тогтоомжийн дагуу түүний нутаг дэвсгэрт гаргасан шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бөгөөд албадан биелүүлэх бол. Харин хүүхдийн тэтгэлгийн үүрэгтэй холбогдсон хэргийн хувьд албадан биелүүлэх бол хуулийн хүчин төгөлдөр болоогүй шийдвэр;
- 2/ нутаг дэвсгэрт нь хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч тухайн Талын дотоодын хууль тогтоомжийн дагуу шийдвэр гаргасан шүүх эрх бүхий байвал;
- 3/ зохигчид нь өөрийн эрхийг хамгаалах боломжоо алдаагүй тухайлбал, шүүхээр хэргийг хянан хэлэлцэхэд оролцоогүй зохигчид шүүхийн зарлан дуудах хуудсыг цаг тухайд нь зохих журмын дагуу хүлээн авсан, харин байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрх зүйн эрхийн чадамжийг нь хязгаарласан тохиолдолд зохих төлөөлүүлэх эрхийг алдуулаагүй бол;
- 4/ нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын шүүхээс хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гаргаснаар тухайн зохигчдын хоорондох хэрэг дуусгавар болоогүй, мөн нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын шүүх урьд нь тухайн зохигчдын хооронд байцаан шийтгэх ажиллагаа явуулаагүй бол;
- 5/ шийдвэр хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт тухайн зохигчдын хоорондох тэр хэрэгт гуравдагч улсын байгууллагаас гаргасан шүүхийн шийдвэр хүлээн зөвшөөрөгдөөгүй болон биелэгдээгүй бол;
- 6/ нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Тал зөрчилдөөний /олон улсын иргэний эрх зүй/ хууль тогтоомжийн дагуу эрх бүхий хууль тогтоомж хэрэглэсэн бол.

30 дугаар зүйл

1. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх тухай хүсэлтийн нутаг дэвсгэрт нь тухайн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий шүүхэд шууд, эсхүл уул хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхээр дамжуулан гаргаж болно.
2. Хүсэлтэд дараахи баримтыг хавсаргана:

1/ хуулийн хүчин төгөлдөр болсон бөгөөд биелүүлбэл зохих шийдвэр, эсхүл түүний баталгаат хуулбар, хүүхдийн тэтгэлгийн хэргийн хувьд хэрэв шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болоогүй, энэ тухай уг шийдвэрт заагаагүй бол түүнийг биелүүлбэл зохих тухай баримт бичиг;

2/ шүүх эсрэг шийдвэр гаргасан, хэргийг нь хэлэлцэхэд оролцоогүй зохигчид нутаг дэвсгэрт нь шийдвэр гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоожийн дагуу шүүхийн зарлан дуудах хуудсыг цаг тухайд нь зохих журмаар авсан бол үүнийг баталсан баримт бичиг, харин тухайн зохигчид эрх зүйн эрхийн хязгаарлагдмал чадамжтай бол энэ талд зохих журмаар мэдэгдсэнийг баталсан баримт бичиг;

3/ энэ зүйлийн 1, 2-т дурдсан баримт бичгийг нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хэл рүү хөрвүүлсэн баталгаат орчуулга.

31 дүгээр зүйл

1. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай асуудлыг авч хэлэлцвэл шүүх зөвхөн энэхүү Гэрээний 29, 30 дугаар зүйлд заасан нөхцөлийг баримталсан эсэхийг тогтооно.
2. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхэд нутаг дэвсгэрт нь шийдвэр хүлээн зөвшөөрөх, биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг хэрэглэнэ. Энэ нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлтэд нэгэн адил хамаарна. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлтэд, түүний хуулбар болон хэргийн оролцогчдод гардуулах хуулбарыг хавсаргана.
3. Хэрэв Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх асуудлаар шүүн таслах ажиллагаа буюу албадан төлүүлэх тухай ажиллагааг зогсоосон бол энэ тухай баримт бичгийг хүсэлтэд хавсаргана.
4. Шүүх нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх тухай шийдвэр гаргахдаа зохигчдоос тайлбар, шийдвэр гаргасан шүүхээс нэмэлт мэдээлэл шаардаж болно.

Зардлын талаарх шийдвэрийг биелүүлэх

32 дугаар зүйл

1. Хэрэв энэхүү Гэрээний 22 дугаар зүйлийн үндсэн дээр байцаан шийтгэх ажиллагаа явуулах зардлаас чөлөөлөгдсөн этгээд хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр энэ зардлыг байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид төлөх үүрэгтэй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий шүүх уг зардлыг гаргуулах тухай шийдвэрийг хүсэлт гаргагчийн өргөдлийг үндэслэн үнэ төлбөргүйгээр нааштай шийдвэрлэнэ.
2. Байцаан шийтгэх ажиллагаа явуулах зардал гэдэгт шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болж буйг гэрчлэхэд зарцуулсан, албадан төлүүлэх бол зохих баталгаатай, түүнчлэн шаардсан баримт бичгийг шилжүүлэхтэй холбогдсон зардал хамаарна.

33 дугаар зүйл

1. Зардлын талаар шийдвэр биелүүлэхийг тогтоож буй шүүх нь уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон эсэх эсхүл албадан биелүүлбэл зохихыг магадлана.
2. Шийдвэрийг биелүүлэх тухай хүсэлтэд хуулийн хүчин төгөлдөр болсон буюу түүнийг биелүүлбэл зохих баталгаа бүхий шийдвэр эсхүл зардлын хэмжээ тогтоосон хэсгийн баталгаат хуулбар, түүнчлэн эдгээр баримт бичгийг гэрчилсэн орчуулгыг хавсаргана.
3. Нутаг дэвсгэрт нь байцаан шийтгэх ажиллагаа явуулах зардлыг улсаас нь урьдчилгаа болгож олгосон Хэлэлцэн тохирогч Талын байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий шүүхэд уг зардлыг нөхөн төлүүлэх тухай хүсэлт гаргаж болно. Энэхүү шүүх нь өөрийн хууль тогтоомжийн дагуу уг зардлыг нөхөн төлүүлэх бөгөөд нөхөн гаргуулсан мөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт үнэ төлбөргүй шилжүүлнэ. Энэ тохиолдолд энэ зүйлийн 1, 2-т заасан журмыг баримтална.

ГУРАВДУГААР ХЭСЭГ

Эрүүгийн хэрэг

Нэгдүгээр бүлэг

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах

34 дүгээр зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг

1. Хэлэлцэн тохирогч Тал нь даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын даалгавраар нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа өөрийн иргэний хувьд, түүнчлэн нутаг дэвсгэрт нь байнга оршин сууж буй бусад этгээдийн хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг хүлээнэ.
2. Энэ зүйлийн 1-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд даалгавар хүлээн авсан Талын эрх бүхий хууль сахиулах байгууллага өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.
3. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг хүлээх үед гарсан үйлдэл нь хохирлыг нөхөн төлүүлэх тухай гомдол үүсгэх бөгөөд энэ хохирлыг нөхөн төлүүлэх тухай хүсэлт гарсан бол уул хүсэлтийг эрүүгийн хэрэгт хамтатган авч үзнэ.

35 дугаар зүйл

Тусгай заалт

1. Хэрэв энэхүү Гэрээний 34 дүгээр зүйлийн 1-д заасан үйлдэл нь даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг гэж тооцогдох боловч даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу захиргааны зөрчил гэж тооцогдох бол даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал өөрийн хууль тогтоомжийн дагуу даалгаврыг авч хэлэлцэнэ.
2. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын даалгавраар энэхүү Гэрээний 34 дүгээр зүйлийн 1-д заасан нөхцөлийн дагуу хууль зөрчсөн үйлдэл гаргасан хэрэг гэж сэжиглэгдэж байгаа насанд хүрээгүй этгээдийн хувьд байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг хүлээнэ.

36 дугаар зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгавар

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгавар нь дараахь зүйлийг агуулна:
 - 1/ даалгавар өгсөн байгууллагын нэр;
 - 2/ сэжиглэгдэж буй этгээдийн овог, нэр, иргэний харьяалал, хувийн бусад байдал;
 - 3/ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгавартай холбогдох хэргийн тодорхойлолт болон хуулийн зүйлчлэл.
2. Түүнчлэн даалгаварт дараахь зүйлийг хавсаргана:
 - 1/ эрүүгийн хуулийн заалтын агуулга, шаардлагатай бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад ач холбогдол бүхий даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хуулийн бусад заалт;
 - 2 /хэрэгт холбогдох баримт бичиг эсхүл түүний баталгаат хуулбар, түүнчлэн нотлох баримт;
 - 3/ хохирлыг нөхөн төлүүлэх тухай хүсэлт болон боломжийн хэрээр хохирлын хэмжээний талаарх бололцоотой мэдээлэл;
 - 4/ даалгавар хүлээн авсан Талын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай гэж үзвэл байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хохирогчийн хүсэлт.

37 дугаар зүйл

Сэжигтэн сэтгээдийг шилжүүлэх

1. Хэрэв эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгаврыг гаргах үед сэжигтэн этгээд нь даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт түр цагдан хоригдож байвал түүнийг даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлэн өгөх арга хэмжээг авна.
2. Хэрэв эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгаврыг гаргах үед сэжигтэн этгээд нь даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр гадуур байгаа бол энэ Тал өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу уг этгээдийг даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд буцаан өгөх арга хэмжээг авна.

38 дугаар зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үр дүнгийн тухай мэдээлэх

Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал хэргийн талаарх эцсийн шийдвэрээ даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ. Энэхүү шийдвэрийн хуулбарыг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын шаардлагаар хүргүүлнэ.

39 дүгээр зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулсны үр дагавар

Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал байцаан шийтгэх ажиллагаа явуулахыг татгалзах буюу хэргийг хэрэгсэхгүй болгох нөхцөлд даалгавар өгсөн Тал тухайн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэх эрхийг хадгалж үлдэх тухай тусгайлан зааснаас бусад тохиолдолд түүний хууль сахиулах байгууллага нь

хэргийг буцаан авсны дараа энэ хэрэгт тухайн этгээдэд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй.

Хоёрдугаар бүлэг
Байцаан шийтгэх ажиллагаа явуулах буюу таслан шийдвэрлэх тогтоолыг
биелүүлэхээр шилжүүлэн өгөх

Шилжүүлэн өгөх үндэслэл
40 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэхүү Гэрээний заалтын дагуу өөрийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах буюу таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхээр харилцан шаардсаны дагуу шилжүүлэн өгнө.
2. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг гэж үзэх хэрэг үйлдсэн бөгөөд энэ хэрэгт зөвхөн нэг жилээс дээш хугацаагаар хорих буюу өөр хүнд ял оногдуулахаар бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар шилжүүлэн өгнө.
3. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг гэж үзэх хэрэг үйлдсэн бөгөөд хэрэв энэ үед шилжүүлэн өгөхийг шаардсан этгээд нь зургаан сараас доошгүй хорих буюу өөр хүнд ялаар шийтгэгдсэн бол таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгнө.

41 дүгээр зүйл

1. Дараахь тохиолдолд шилжүүлэн өгөхгүй. Хэрэв:
 - 1/ шилжүүлэн өгөхийг шаардсан этгээд нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын иргэн эсхүл түүний нутаг дэвсгэрт орогнох эрхтэй бол;
 - 2/ шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг үйлдэгдсэн бол;
 - 3/ шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсхүл хуульд заасан бусад үндэслэлээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах буюу таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх боломжгүй болсон бол;
 - 4/ шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийн хувьд тэр гэмт хэрэгт нь эрүүгийн хэрэг үүсгэсэн, хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр гарсан эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай тогтоол гарсан бол;
 - 5/ эрүүгийн хэрэг нь хувийн гомдлоор үүссэн бол;
 - 6/ гэмт хэрэг нь улс төрийн шинж чанартай бол тодорхой тохиолдлын нөхцөл байдал тооцсоноос тухайлбал, үйлдлийн сэдэлт, ашигласан болон ашиглахаар заналхийлсэн арга хэрэгсэл, түүнчлэн бодит үр дагаврыг харгалзан үзэхэд улс төрийн гэхээс эрүүгийн шинжтэй гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэгт тооцохгүй;
 - 7/ зөвхөн цэргийн үүргийг зөрчөнтэй холбогдсон гэмт хэрэг бол;
 - 8/ энэ нь нийгмийн хэв журам болон эрх зүйн зарчмыг зөрчсөн бол.
2. Шилжүүлээгүй тохиолдолд шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлэхээс татгалзсан тухай үндэслэлийг мэдэгдэнэ.

42 дугаар зүйл

Цаазаар авах ялтай холбогдсон хэргийг шилжүүлэх хязгаар

Хэрэв гэмт хэрэгт шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу цаазаар авах, харин шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу тухайн ял байхгүй бол шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр цаазаар авах ялын талаар шийдвэр гаргаж болохгүй бөгөөд цаазаар авах ялыг гүйцэтгэж болохгүй.

43 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай даалгавар

1. Эрүүгийн хэрэг үүсгэхээр шилжүүлэн өгөх тухай даалгаварт шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийг цагдан хорих тухай тогтоолын баталгаат хуулбар, түүний гэмт үйлдлийн тодорхойлолт болон холбогдох хуулийн заалтыг хавсаргана. Эд хөрөнгийн эсрэг гэмт хэргийн хувьд гэмт үйлдлийн улмаас учирсан болон учирч болзошгүй эд хөрөнгийн хохирлын хэмжээг заасан байна.
2. Таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгөх тухай шаардлагад хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолын баталгаат хуулбар, ялтан этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт холбогдох хуулийн заалтыг хавсаргана. Ялтан этгээд ял эдэлж эхэлсэн тохиолдолд эдэлсэн хугацааг заасан байна.
3. Хэрэв таслан шийдвэрлэх буюу баривчлах тухай тогтоолд энэ тухай заагаагүй бол шилжүүлэн өгөх тухай даалгаварт шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийн гадна төрх байдлын тухай тодорхойлолт,

иргэний харьяалал, гэр бүл, оршин байгаа газрын талаарх мэдээ болон түүний гэрэл зураг, хурууны хээг хавсаргана.

44 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөх тухай шаардлагад хамаарах нэмэлт мэдээ

Хэрэв шилжүүлэн өгөх тухай даалгавар биелүүлэхэд хүлээн авсан мэдээ нь хангалттай бус байвал шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нэмэлт мэдээ шаардаж болох бөгөөд үүний тулд хоёр сар хүртэлх хугацаа тогтооно. Хүндэтгэн үзэх шалтгаантай бол энэ хугацааг сунгаж болно.

45 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх этгээдийг баривчлах

Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгөх тухай шаардлагыг хүлээн авмагц энэхүү Гэрээний дагуу шилжүүлэн өгөхгүй байх тохиолдлоос бусад үед шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийг баривчлах арга хэмжээг нэн даруй авах ёстой.

46 дугаар зүйл

1. Хэрэв шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгөх тухай шаардлагад цагдан хорих буюу таслан шийдвэрлэх тогтоолын заалтыг иш үндэс болговол шилжүүлэн өгөх тухай шаардлага өгөхөөс өмнө гэмт этгээдийг баривчилж болно. Баривчлах тухай хүсэлтийг шуудан, цахилгаан утсаар буюу ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй бусад хэрэгслийн туслалцаатай хүргүүлнэ.
2. Энэ зүйлийн 1-д заасны дагуу баривчилсан тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд нэн даруй мэдэгдэнэ.

47 дугаар зүйл

Баривчлагдсан этгээдийг суллах

1. Шилжүүлэн өгөх тухай шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал хэрэв энэхүү Гэрээний 44 дүгээр зүйлд дурдсан хугацаанд энэ Талын шаардсан нэмэлт тайлбар ирүүлээгүй бол энэхүү Гэрээний 45 дугаар зүйлийн дагуу баривчлагдсан этгээдийг суллаж болно.
2. Хэлэлцэн тохирогч нөгөө Талд уг этгээдийг баривчлагдсан тухай мэдэгдсэн өдрөөс хойш нэг сарын дотор түүнийг шилжүүлэн авах тухай шаардлага ирүүлээгүй бол энэхүү Гэрээний 46 дугаар зүйлийн 1-д заасны дагуу баривчлагдсан этгээдийг суллана.

48 дугаар зүйл

Шилжүүлэн өгөхийг хойшлуулах

Хэрэв шилжүүлэн өгөхийг шаардсан этгээд нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр эрүүгийн хариуцлагад татагдсан буюу өөр гэмт хэргийн учир ял шийтгүүлсэн бол түүнийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж дуусгах, эсхүл оногдуулсан ялыг эдэлждуусгах, ял эдлэх хугацаанаас нь өмнө суллах хүртэл шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

49 дүгээр зүйл

Түр шилжүүлэн өгөх

1. Хэрэв шилжүүлэн өгөхийг хойшлуулах нь эрүүгийн хэрэг үүсгэх хөөн хэлэлцэх хугацаа дуусахаар буюу гэмт хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд ноцтой бэрхшээл учруулахаар байвал шилжүүлэн өгвөл зохих этгээдийг шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын үндэслэл бүхий шаардлагаар түр шилжүүлэн өгч болно.
2. Түр шилжүүлэн өгсөн этгээдийг байцаан шийтгэх ажиллагаа дууссаны дараа нэн даруй, гэхдээ түр шилжүүлэн өгсөн өдрөөс эхлэн гурван сараас хэтрэхгүй хугацаанд буцаан шилжүүлэн өгөх ёстой.

50 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай шаардлагын талаарх зохицуулалт

Хэрэв нэг этгээдийг шилжүүлэн өгөхийг хэд хэдэн улс зэрэг шаардаж байгаа бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал тухайн этгээдийг аль улсад шилжүүлэн өгөхийг шийдвэрлэнэ. Иймд шийдвэр гаргахдаа бүх нөхцөл байдал тухайлбал, уг этгээдийн иргэний харьяалал, гэмт хэргийг үйлдсэн газар болон түүний шинж чанарыг харгалзан үзнэ.

51 дүгээр зүйл

Шилжүүлэн өгсөн этгээдийн эрүүгийн байцаан шийтгэх хязгаар

1. Шилжүүлэн өгсөн этгээдийг шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, ял шийтгэх, түүнчлэн шилжүүлэн өгөхөөс өмнө үйлдсэн болон шилжүүлэн өгөөгүй бусад гэмт хэрэгт нь гуравдагч улсад шилжүүлэн өгч үл болно.
2. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрөл дараахь тохиолдолд шаардагдахгүй:
1/шилжүүлэн өгсөн этгээд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа буюу ял эдэлж дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс гарч яваагүй бол. Энэ хугацаанд шилжүүлэн өгсөн этгээд шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс өөрөөс нь үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас гарч яваагүй хугацааг оруулан тооцохгүй;
2/шилжүүлэн өгсөн этгээд шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс явсан боловч тухайн нутаг дэвсгэрт сайн дураар буцаж ирсэн бол.

52 дугаар зүйл Шилжүүлэх

Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал уг этгээдийг шилжүүлэн өгөх газар, цаг хугацааг шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ. Хэрэв шилжүүлэн өгөх этгээдийг шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал нь шилжүүлэн өгөхөөр тогтоосон хугацаанаас хойш 15 хоногийн дотор хүлээн авахгүй бол уг этгээдийг суллаж болно.

53 дугаар зүйл Дахин шилжүүлэн өгөх

Шилжүүлэн өгсөн этгээд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас, эсхүл ял эдлэхээс зайлсхийж шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт буцаж ирвэл энэхүү Гэрээний 43 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлэхгүйгээр шинэ шаардлагын дагуу уг этгээдийг дахин шилжүүлэн өгнө.

54 дүгээр зүйл Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дүнгийн тухай мэдээлэх

Шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгсөн этгээдийн талаар явуулсан байцаан шийтгэх ажиллагааны дүнгийн тухай шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд нэн даруй мэдэгдэнэ. Хэргийн талаар гаргасан шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд уг шийдвэрийн хуулбарыг хүргүүлнэ.

55 дугаар зүйл Дамжин өнгөрүүлэх

1. Хэлэлцэн тохирогч нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шаардлагын дагуу гуравдагч улсаас шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлэн өгсөн этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл өгнө. Энэхүү гэрээний дагуу шилжүүлэн өгөх үүрэг хүлээхгүй бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал зөвшөөрөл өгөхгүй байж болно.
2. Дамжин өнгөрүүлэх тухай шаардлагыг шилжүүлэн өгөх тухай шаардлагатай адил журмаар үйлдэж хянан шийдвэрлэнэ.
3. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь өөртөө илүү тохиромжтой нөхцөлөөр дамжин өнгөрүүлнэ.
4. Агаарын замаар буухгүй дамжин өнгөрөх тохиолдолд дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл авах шаардлагагүй.

56 дугаар зүйл Шилжүүлэн өгөх болон дамжин өнгөрүүлэхтэй холбогдсон зардал

Шилжүүлэн өгөхтэй холбогдсон зардлыг уг зардал нутаг дэвсгэрт нь гарсан Хэлэлцэн тохирогч Тал хариуцна. Дамжин өнгөрүүлэхтэй холбогдсон зардлыг шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал хариуцна.

ГУРАВДУГААР ХЭСЭГ Эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн туслалцаанд хамаарах тусгай заалт

57 дугаар зүйл

Хорих ял шийтгэгдсэн этгээдийг түр шилжүүлэх

1. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт хорих ял шийтгэгдсэн этгээдийг гэрчээр байцаах зайлшгүй шаардлага гарвал энэ Талын эрх бүхий байгууллага шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт түүнийг хүргүүлэх тухай захирамж өгнө. Уг этгээдийг цагдан хорих бөгөөд байцаалтын дараа нэн даруй буцааж шилжүүлнэ.
2. Гуравдагч улсын нутаг дэвсгэр дээр хорих ял шийтгэгдсэн этгээдийг гэрчээр байцаах зайлшгүй шаардлагатай бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага түүнийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхийг зөвшөөрнө.

58 дугаар зүйл

Эд зүйлийг шилжүүлэх

1. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал буруутай этгээдийн гэмт хэргийн үр дүнд олж авсан эд зүйл, түүнчлэн эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаанд эд мөрийн нотлох баримт болж болох эд зүйлийг шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлэн өгнө.
2. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал хэрэв уг эд зүйл нь өөр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд шаардлагатай бол түүнийг шилжүүлэхийг түр хойшлуулж болно.
3. Хэлэлцэн тохирогч нөгөө Талд шилжүүлэн өгсөн эд зүйлийн хувьд гуравдагч этгээдийн эрх халдашгүй хэвээр үлдэнэ. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дууссаны дараа уг эд зүйлийг шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч Талд буцаах, эсхүл энэ Талын зөвшөөрснөөр эзэмших эрх бүхий этгээдэд шууд шилжүүлэн өгнө.
4. Энэ зүйлийн дагуу эд зүйлийг шилжүүлэхэд эд зүйл болон валютын үнэт зүйлийг оруулах, гаргахыг хязгаарласан хууль хэрэглэхгүй.

59 дүгээр зүйл

Таслан шийдвэрлэх тогтоолын тухай мэдээлэх

Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний хувьд гаргасан хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоолын тухай харилцан мэдээлж байна.

60 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Тал бүр шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын иргэн бус этгээдийн хувьд Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхээс гаргасан хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоолын талаарх мэдээллийг үндэслэл бүхий шаардлагаар харилцан өгч байна.

61 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэхүү Гэрээний 59, 60 дугаар зүйлд дурдсан этгээдийн хурууны хээг харилцан хүссэний дагуу хүргүүлнэ.

62 дугаар зүйл

Ялтны бүртгэлийн тухай мэдээ

Хэлэлцэн тохирогч хоёр Тал ялтны тухай бүртгэлээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнд хамаарах ял шийтгэгдсэн тухай бүрэн мэдээг, түүнчлэн шүүх нь шийдвэр гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу тухайн мэдээ, хэрэв бүртгэдэг бол таслан шийдвэрлэх тогтоолд хамаарах сүүлд гаргасан шийдвэрийн талаарх мэдээг харилцан шаардсаны дагуу бие биедээ дамжуулж байна.

63 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэх үед төлөөлөгчид байлцах

Хэлэлцэн тохирогч Талын төлөөлөгчид энэхүү Гэрээний 4 дүгээр зүйлийн 1-д заасан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын төв байгууллагын зөвшөөрснөөр түүний нутаг дэвсгэрт эрх зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд аливаа ажиллагаа явуулах үед байлцаж болно.

Дөрөвдүгээр бүлэг
Эрүүгийн асуудлаарх шүүхийн шийдвэрийг биелүүлэх

64 дүгээр зүйл
Тодорхойлолт

1. Энэ бүлэгт "эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ" гэсэн нэр томъёог:
1/Монгол Улсын хувьд- гэм буруутан этгээд сэтгэцийн өвчинтэй, эсхүл согтуурах болон мансуурах донтой эсэхийг нь тогтоолгохоор, хэрэв ийм магадлагаатай бол түүнийг эмчлүүлэхээр мэргэжлийн эмнэлгийн байгууллагад шилжүүлэхийг;
2/Бүгд Найрамдах Польш Улсын хувьд - буруутан этгээдийг сэтгэл мэдрэлийн эмнэлэг буюу бусад холбогдох эмнэлгийн газар хэвтүүлэх болон буруутан этгээдийг наркологийн эмчилгээний газарт хэвтүүлэх гэж тус тус ойлгоно.
2. Энэ бүлэгт дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
"таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс" гэж хорих ял оногдуулах буюу эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх хэлбэрээр ял шийтгэлийг гүйцэтгүүлэхээр тодорхойлсон шүүхийн шийдвэр гаргасан улсыг;
"таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улс" гэж хорих ял оногдуулах буюу эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх хэлбэрээр ял шийтгэлийг гүйцэтгэх үүргийг өөртөө хүлээсэн, эсхүл хүлээх ёстой улсыг тус тус хэлнэ.

65 дугаар зүйл
Ерөнхий зарчим

1. Энэхүү Гэрээний заалтын дагуу хэлэлцэн тохирогч нэг Талын шүүх Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнд хорих ял оногдуулах буюу эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх хэлбэрээр ял шийтгэх тухай хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гаргах үндэслэл болсон эрүүгийн хэргээр Хэлэлцэн тохирогч хоёр Тал таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхээр даалгавар авах үүрэг харилцан хүлээнэ.
2. Энэ зүйлийн 1-д дурдсан даалгаврыг энэ Гэрээний 4 дүгээр зүйлийн 1-д тодорхойлсон таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс болон таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын төв байгууллага бүр өгч болно.

66 дугаар зүйл
Ялтан этгээдийн эрх

1. Ялтан этгээд, түүний хууль ёсны болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, гэр бүл, ойрын садан төрлийн хүмүүс буюу төрсөн ах, эгч нар нь энэ Гэрээний 65 дугаар зүйлд дурдсан ажиллагааг явуулах тухай санал, хүсэлтээ Хэлэлцэн тохирогч аль ч Талд тавьж болно.
2. Энэхүү Гэрээнд заасан нөхцөлд хамаарагдах аливаа ялтан этгээдэд таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс энэ бүлгийн заалтын тухай мэдэгдэнэ.

67 дугаар зүйл
Шүүхийн шийтгэлийн тухай шаардлага

Шийдвэр гаргахад үндэслэл болсон үйлдэл нь таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийтгэгдэх, эсхүл уг үйлдэл таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн тохиолдолд шүүхээр мөн шийтгэгдэх тохиолдолд шийдвэрийг биелүүлэхээр хүлээн авна.

68 дугаар зүйл
Улс төрийн гэмт хэрэг

1. Хэрэв шийдвэр гаргахад үндэслэл болсон үйлдэл нь улс төрийн шинжтэй гэмт хэрэг бол шийдвэрийг биелүүлэхээр хүлээн авахгүй.
2. Тодорхой тохиолдлын бүх нөхцөл байдлыг тухайлбал, үйлдлийн сэдэлт, арга, ашигласан арга хэрэгсэл буюу тэдгээрийг ашиглахдаа заналхийлсэн, түүнчлэн бодит буюу төлөвлөж байсан үр дагаврыг нь хянан хэлэлцэхэд эрүүгийн хэргийн давуу шинжтэй гэмт хэргийг улс төрийн шинжтэй гэмт хэрэгт тооцохгүй.

69 дүгээр зүйл
Цэргийн гэмт хэрэг

Хэрэв шийдвэр гаргахад үндэслэл болсон үйлдэл нь зөвхөн цэргийн үүргээ зөрчсөн шинжтэй бол шийдвэрийг биелүүлэхээр хүлээн авахгүй.

70 дугаар зүйл
Санхүүгийн гэмт хэрэг

Санхүүгийн гэмт хэргийн талаарх таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр хүлээн авахад татвар, хураамж, дангаар ноёрхох, валютын гүйлгээ, гадаад худалдаа буюу бараа солилцооны дэглэмтэй холбогдолтой заалт тухайн улсын хууль тогтоомжид байхгүй гэсэн шалтгаанаар татгалзаж болохгүй.

71 дүгээр зүйл
Хөөн хэлэлцэх хугацаа дуусах

Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хууль тогтоожийн дагуу ял шийтгэх буюу эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол Таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр хүлээн авахгүй.

72 дугаар зүйл
Тусгай шүүх

Тусгай шүүхээс гаргасан таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр хүлээн авахгүй.

73 дугаар зүйл
Шүүгдэгчийг эзгүйд гаргасан таслан шийдвэрлэх тогтоол

Шүүгдэгчийг эзгүйд гаргасан таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр хүлээн авахгүй.

74 дүгээр зүйл
Давхар шийтгэхийг хориглох

Хэрэв ялтан этгээд таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсад тухайн хэргээр хуулийн дагуу шийтгэгдсэн, эсхүл цагаатгагдсан бол таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр хүлээн авахгүй.

75 дугаар зүйл
Нийгмийн хэв журмыг сахих

Хэрэв ялтан этгээд таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх нь нийгмийн хэв журам буюу эрх зүйн зарчмыг зөрчихөөр бол уг тогтоолыг биелүүлэхээр хүлээн авахгүй.

76 дугаар зүйл
Хүлээн авах нөхцөл

1. Таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр зөвхөн ялтан этгээдийн зөвшөөрснөөр хүлээн авч болно. Хэрэв ялтан этгээд зөвшөөрөл илэрхийлэх чадваргүй бол түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг заавал авсан байна.
2. Хэрэв ялтан этгээд таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад хоригдож байгаа болон даалгавар ирсэн өдөр хорих ялын буюу эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үлдсэн хугацаа нь дөрвөн сараас хэтрэхгүй бол таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр хүлээн авахгүй. Энэ хугацааг тооцох үед хорих ялын болон эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний, түүнчлэн тэдгээрийн эдлэхээр үлдсэн хугацааг нэмнэ. Хэрэв эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх хугацааг тогтоогоогүй бол таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсын хууль тогтоомжийн дагуу уг арга хэмжээг хэрэглэх хугацаа дуусах хамгийн сүүлчийн өдрийг оруулан тооцно.

77 дугаар зүйл
Шаардлага хэлэлцэх

Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал түүнийг ямар хэмжээнд биелүүлсэн талаар шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талд аль болох богино хугацаанд мэдэгдэнэ. Шаардлагыг нь бүхэлд нь буюу хэсэгчилсэн байдлаар татгалзсан бол түүний үндэслэлийг нотолсон байна.

78 дугаар зүйл
Шийдвэр биелүүлэх

1. Шийдвэрийг биелүүлэхээр хүлээн авсан тохиолдолд таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын шүүх нь өөрийн хууль тогтоомжийн дагуу хорих ял буюу эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохих ёсоор биелүүлэх хугацааг таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсын шүүхийн шийдвэрт заасан хэмжээтэй нэгэн адил тогтооно. Хэрэв таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын хууль тогтоомжид тухайн гэмт хэрэгт хорих ялын хамгийн дээд хэмжээг оногдуулахаар заасан нь таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсын шүүхийн шийдвэрт тогтоосон ял шийтгэлийн хугацаанаас бага байвал таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын шүүх нь өөрийн улсын хууль тогтоомжид заасан уг гэмт хэрэгт ногдуулах хорих ялын дээд хэмжээг тогтооно.
2. Таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улс шийдвэрийг биелүүлэхээр хүлээн авсны дүнд ялтан этгээдийн байдал нь таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад шийдвэрийг биелүүлэх үед байх байдлаас ямар ч тохиолдолд дор байх ёсгүй.
3. Тогтоолыг тэнсэх журмаар биелүүлэх ажиллагааг таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын хууль тогтоомжид нийцүүлэн явуулна. Хэрэв таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсын тэнсэх ялыг зохицуулж буй хууль тогтоомж нь ялтан этгээдэд илүү хөнгөлттэй нөхцөл үүсгэж байвал уг хуулийг баримтална.
4. Таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсад хорих ял болон эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх хугацаанд таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад хорих болон эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэсэн хугацааг оруулан тооцно.

79 дүгээр зүйл

Тогтоолыг хэсэгчлэн биелүүлэх

Хэрэв шийтгэл нь нэгээс дээш гэмт хэрэгт оногдсон, харин хорих ял болон эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх тухай тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэх нь зөвхөн зарим гэмт хэрэгт хамаарах бол уг таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын шүүх энэхүү Гэрээний 78 дугаар зүйлд нийцүүлэн эдгээр гэмт хэрэгтэнд хорих ял болон эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх эсэхийг тогтооно.

80 дугаар зүйл

Тогтоол биелүүлэхээр хүлээн авсны үр дагавар

1. Хорих ял болон эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх шийтгэлийг таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсад гүйцэтгэх үед таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс нь гүйцэтгэлтэй холбоотой цаашдын үйл ажиллагаанд оролцохгүй.
2. Ялтан этгээд ял эдлэхээс зайлсхийн таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын нутаг дэвсгэрээс оргож гарсан бол таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс нь оногдуулсан ял шийтгэлийн үлдсэн хэсгийг бүрэн эдлүүлэх талаар эрх бүхий байна. Таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улс нь таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад энэ тухай нэн даруй мэдэгдэнэ.
3. Хорих ял болон эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх шийтгэл гүйцэтгэгдсэн буюу өөрчлөгдсөн бол энэ зүйлийн 2-т заасны дагуу таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсын эрх хэмжээ дуусгавар болсонд тооцогдоно.

81 дүгээр зүйл

Уучлал, өршөөл үзүүлэх

1. Ялтан этгээдэд таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улс уучлал, өршөөл үзүүлж болно. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс нь таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсад уучлал үзүүлэх санал гаргаж болно. Таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улс уг саналд нааштай хандана. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс нь өөрийн нутаг дэвсгэр дээр уучлал үзүүлэх эрхтэй.
2. Таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улс ялтан этгээдэд таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсаас үзүүлсэн өршөөлийг таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсад үзүүлсэн өршөөлтэй хамтад нь хэрэглэнэ.

82 дугаар зүйл

Тогтоолд өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох

Зөвхөн таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс гүйцэтгэгдэх шатандаа байгаа тогтоолыг өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй.

83 дугаар зүйл

Мэдэгдэл

1. Хэлэлцэн тохилогч хоёр Тал аль болох богино хугацаанд тогтоол биелүүлэхэд нөлөөлж болох нөхцөл байдлын тухай мэдэгдлийг хоорондоо солилцоно.
2. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс нь таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсад гүйцэтгүүлэх тогтоолыг хүчингүй болгосон буюу өөрчилсөн, өршөөл үзүүлсэн тухайгаа мэдэгдэнэ.
3. Таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улс нь таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад уг тогтоолыг биелүүлсэн тухай мэдээлнэ.

84 дүгээр зүйл

Шилжүүлэх

1. Хэрэв ялтан этгээд таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсын нутаг дэвсгэрт байгаа бол тухайн улс аль болох богино хугацаанд таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын зохих байгууллагад уг этгээдийг шилжүүлэх арга хэмжээ авна.
2. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс, таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улстай ялтан этгээдийг таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсын байгууллагад шилжүүлэн өгөх газар хугацаа хэрэв шаардлагатай бол дамжин өнгөрөх улсын холбогдох байгууллагатай энэ талаар тохиролцоно.
3. Гэмт этгээдийг нөгөө улсад агаарын замаар хүргэж өгөх буюу авчрахад байлцах үүрэгтэй Хэлэлцэн тохилогч аль нэг Талын харгалзагчид нөгөө орны нутаг дэвсгэр дээр уг этгээдийг шилжүүлэн өгөх хүртлээ оргуулахгүй байх талаар урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авна.
4. Тогтоолыг биелүүлэх тухай шийдвэрийг таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсад шилжүүлсний дараа таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс ялтан этгээдийг бусад гэмт хэрэгт холбогдуулж мөрдөн байцаалт явуулах, хорих ял болон эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх зорилгоор шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

85 дугаар зүйл

Ялтан этгээдийг эрүүгийн байцаан шийтгэх хязгаар

1. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс нь энэхүү Гэрээнд заасны дагуу ялтан этгээдийг таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсад шилжүүлсэн бол тогтоол гүйцэтгэхтэй холбогдолгүй шилжүүлэн өгөх үед гаргасан үйлдэлд нь байцаах, шийтгэх болон бусад аргаар эрхийг нь хязгаарлаж болохгүй.
2. Энэ зүйлийн 1-д заасан хязгаарлалт дараахь тохиолдолд хамаарахгүй:
1/ таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс нь мөрдөн байцаалт явуулах, шийтгэл гүйцэтгэх, эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх зөвшөөрөл өгсөн бол;
2/ шилжүүлэн өгсөн ялтан этгээд таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсад ял эдэлж суллагдсанаас хойш тухайн улсын газар нутгийг орхих боломжтой байсан хэдий ч 30-аас дээш хоногоор үлдсэн, эсхүл тухайн улсаас гарч явсны дараа сайн дураар эргэж ирсэн бол.

86 дугаар зүйл

Хүсэлт, хавсралт бичиг

1. Энэ бүлэгт заасан хүсэлт бичгээр үйлдэгдэнэ.
2. Таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улсад гаргах хүсэлтэд дараахь зүйлийг хавсаргана:
1/ тогтоолын эх бичвэр, эсхүл хүчин төгөлдөр болсон буюу гүйцэтгэгдсэнийг гэрчилсэн тэмдэглэл буюу хуулбар;
2/ хэрэглэсэн хуулийн заалт, батлан даалтаар сулласан үндэслэл;
3/ ялтан этгээдийн дэлгэрэнгүй бүртгэл, иргэний харьяалал, оршин суудаг газар, өмнө байсан газрын хаяг;
4/ хорих ял болон эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэсэн хугацааны тухай бүртгэлд орох тодорхойлолт;
5/ хорих ял болон эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх ялыг гүйцэтгүүлэхээр шилжүүлэхэд ялтан этгээд, түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг баталсан баримт бичиг;
6/ хүсэлт шийдвэрлэхэд хамаарах бусад баримт бичиг;
7/ энэ заалтад дурдсан хүсэлт, баримт бичгийг Хэлэлцэн тохилогч нөгөө Талын хэл рүү хөрвүүлсэн орчуулга.
3. Таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх улсад гаргах хүсэлтэд энэ зүйлийн 2-ын 3, 6, 7-д заасан мэдээлэл, баримт бичгийг хавсаргана.
4. Хэрэв энэ зүйлийн 3-т дурдсан хүсэлтийг хүлээн авбал таслан шийдвэрлэх тогтоол гаргасан улс энэ зүйлийн 2-ын 1, 2, 4, 5-д дурдсан баримт бичгийг Хэлэлцэн тохилогч нөгөө Талын хэл рүү хөрвүүлсэн орчуулгын хамт хүргүүлнэ.

87 дугаар зүйл
Хүсэлтэд нэмэлт хийх

Хэрэв даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал мэдээлэл, баримт бичгийг гүйцэд бус байна гэж үзвэл нэмэлт мэдээлэл шаардаж болно. Ийм нэмэлт мэдээлэл авахын тулд даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал хугацаа тогтоож болно. Үндэслэл бүхий хүсэлтээр уг хугацааг сунгаж болно. Нэмэлт мэдээлэл ирээгүй тохиолдолд тухайн нөхцөлд байгаа мэдээлэл, баримт бичигт үндэслэн шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ
Төгсгөлийн заалт

88 дугаар зүйл

Энэхүү Гэрээ нь Хэлэлцэн тохирогч аль нэг буюу хоёр Талын байгуулсан бусад гэрээнээс үүдэн гарах үүргийг хөндөхгүй.

89 дүгээр зүйл

Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичгийг солилцсон өдрөөс эхлэн 60 хоног өнгөрсний дараа хүчин төгөлдөр болно. Батламж жуух бичгийг Улаанбаатар хотноо солилцоно.

90 дүгээр зүйл

Энэхүү Гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулав. Хэлэлцэн тохирогч Тал бүр нот бичиг илгээх замаар Гэрээг цуцалж болно. Энэ тохиолдолд цуцалсан өдрөөс хойш зургаан сарын дараа Гэрээг хүчингүй болсонд тооцно.

Энэхүү Гэрээг өдөр Варшав хотноо монгол, польш хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд хоёр эх бичвэр адил хүчинтэй байна.

Үүнийг баталгаа болгон Хэлэлцэн тохирогч хоёр Талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид энэхүү Гэрээнд гарын үсэг зурж, тамга дарав.

-000-